

**Угсаатны уламжлалт дууг аман зохиолын онол,
арга зүйн үүднээс судлах боломж**
(Үзэмчин уртын дуу, өнөөгийн байдлын судалгаагаар)

Аюушжавын АЛИМАА*

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Аман зохиол судлалын салбар

Алтан-Уулын ТОГТОХ /Taogete/**

Монгол Улсын Соёл урлагийн их сургуулийн
Хөгжим урлагийн сургууль

Received: Jun 14, 2024

Revised: Jul 18, 2024

Accepted: Aug, 20, 2024

Хураангуй: Монгол үндэстэн нь өөртөө дуу, хөгжмийн өвөрмөц онцлог бүхий угсаатны олон бүлгийг нэгтгэсэн байх бөгөөд тэдгээрийг орчин цагийн хөгжим судлалаар шинжлэн судлах нь зүйн хэрэг боловч шинжлэх ухааны бусад салбар, тухайлбал, угсаатны зүй, нийгэм-соёлын антропологи зэргээс гадна аман зохиол судлалын үүднээс хандан судалбал тохиромжтой болох талаар санал дэвшүүлжээ. Чингэхдээ үзэмчин уртын дууны өв сан, өнөө цагийн байдлын талаар өөрсдийн хийсэн аман зохиол судлалын чиг баримжаатай хийсэн шинжилгээний анги, үзэмчин уртын дуучид, сонирхогчид, хүмүүсээс авсан асуулга судалгааны дүнд түшиглэн баримт нотолгоог өгүүлжээ.

Түлхүүр үг: Аман зохиол судлал, аман зохиолын онол, уртын дуу, үзэмчин, үзэмчин уртын дуу, үзэмчин дуу,

* © А.Алимаа.

Email: Alimaaa@mas.ac.mn

** © А.Тогтох/Taogete/

Email: atogtohtogtoh@gmail.com

**Possibilities on studying ethnic songs from
theoretical and methodological aspects**
(Long song of Uzemchin, current situation)

ALIMAA Ayushjav
Department of the Folklore studies, Institute of Language and
Literature, Mongolian Academy of Sciences, Mongolia

ТОГТОХ /Taogete/ Altanuul
School of music art, Mongolian State University of
Arts and Culture

Abstract: The Mongolian nation unites many ethnic groups with their unique songs and music. It is natural to analyse them in terms of musicological theory, but it is suggested to study them from the perspective of oral literature.

The authors conducted a two-phase expedition to the lands of Uzemchi people living in the regions of Inner Mongolia and China in 2020 and 2023-2024, using the method of field analysis of oral literature. They met and made observations, interviewed and questionnaires about 50 people who know and sing the long song 'Uzemchin', will conduct oral reading. The author presents a scheme based on the accounting and distribution of Uzemchin and especially their folk broach songs by the method of folklore card index.

The article concludes that it is expedient to study the song folklore of an ethnos by the methods of oral folk art, combining them with ethnomusicology.

Key words: long song, literature, analyse, method, uzemchin, folklore, card

I. Удиртгал


Соёлын ижилсэл, хүчтэй нөлөөллийн эрхшээлд орж буй өнөөгийн цаг үед угсаатны бүлгүүд, тэдний нийгэм соёлын динамик, уламжлал, зан заншлыг иж байдлаар судлах нь улам бүр чухал болсоор байна. Үүнийг тухайн угсаатан хамгийн түрүүнд ухаарч судалж, тодорхой ажлуудыг хийж байгаа нь соёлын дархлаагаа бэхжүүлж буй хэрэг гэлтэй. Тухайлбал, ӨМӨЗО-ны дуу судлаач Бөххад 2005 онд “Үзэмчин ардын домогт дуу”, дараа онд нь “Монгол уртын дууны өлгий-Үзэмчин” (эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл), 2012 онд Т.Санжээ “Үзэмчин ардын дуу” эмхэтгэлийг хэвлүүлсэн бол 2023 онд Да.Сэрэннамжил, Г.Цагаанхүү нарын “Үзэмчин уртын дуу, түүний үүсэл гарал” номыг дурдаж болно. Тэгвэл Монгол Улсад өнөө хэр үзэмчин уртын дууны эмхэтгэл түүвэр, судалгааны бүтээл гараагүй байна. Энэ нь энэхүү сэдвийг хөндөх шалтгаан юм.

Сэдвийг сонгох өөр нэг чухал үндэслэл бол үзэмчингүүд өдгөө Монгол Улсын Дорнод аймгийн Сэргэлэн, Баянтүмэн, Булган сум¹, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 3-р багт², БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Зүүн, Баруун үзэмчин хошуу, Шилийн хотын Цог-Уул сум, Төгрөг сум, Долооннуур, Улаанцавын цахар баруун уулын Хөвөөт хөх хошуу, Их зуу аймгийн Эзэн хорго хошуу, Жирэм аймгийн Дархан түшээт хошуунд төвлөрсөн болон тархмал байдлаар харьяалагдан тодорхой газар нутгуудад оршин амьдарч байна.

Монгол Улсын хүн амд үндэстэн, угсаатны эзлэх хувь хэмжээг 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын нэгдсэн статистикаас харвал үзэмчингүүдийн хувьд дараах тоон үзүүлэлт гарна (Үндэсний статистикийн хороо, 2020, 51).

Бүдүүвч 1. Монгол Улс дахь угсаатны бүлгүүдийн хүн амын тоо

ЗУРАГ 3. 26 МОНГОЛ УЛСЫН ХҮН АМД ҮНДЭСТЭН УГСААТНЫ ЭЗЛЭХ ХУВЬ 2020 ОН



Эх сурвалж: Монгол Улсын хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын материал. Сэдэвчилсэн судалгаа

2020 оны байдлаар БНХАУ-ын ӨМӨЗО-ы хэмжээгээр үзэмчин хүн амын тоо 90000 гаруй байна. БНХАУ дахь нийт монгол үндэстэн хүн амын (өвөр монгол, барга буриад, ойрад) тооноос монгол хэлээрээ ярихаа больсон хүн амын тоог хасвал Хятадад амьдарч буй монгол хэлтэн монголчуудын тоо 4644600 орчим болно. Тэгвэл үзэмчин угсаатан хүн ам нь тэдний 1,9 хувийг эзэлж байна. Үүний дотор ӨМӨЗО-ы хувьд,

¹ Дорнод аймгийн 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын статистик үзүүлэлтэд, аймгийн ний хүн амын 70.3%-ийг халх, 20.8%-ийг буриадууд эзэлж байхад үзэмчингүүд 2.1%-ийг бүрдүүлэх ба тэдний 41.2% нь хөдөө нутагт амьдарч байгаа юм (Дорнод аймгийн статистик, 2021). Уг баримт бичигт “Харин Барга, Үзэмчин, Буриад угсаатнуудын нийт хүн амд эзлэх хувь 2010 оноос буурсан байна” (ДАЗДДСХ 2020, 50) гэжээ.

² Сүхбаатар аймгийн 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын дүн мэдээгээр аймгийн хэмжээнд үзэмчингүүдийн эзлэх хувь 0.3%-ийг эзэлж байна (Сүхбаатар аймгийн статистик, 2021).

Хүснэгт 1. БНХАУ-ын ӨМӨЗО дахь үзэмчин угсаатны тоо

Д/д	ӨМӨЗО-ны Шилийн гол аймаг	Тоо	Хүн амын дотор эзлэх хувь
1	Зүүн үзэмчин хошуу	43922 хүн	
2	Баруун үзэмчин хошуу	45419 хүн	

Эх сурвалж: БНХАУ-ын ӨМӨЗО-ы хүн амын статистик үзүүлэлт. 2020 он.

Бид аман зохиол судлалын аргазүйгээр 9 зүйлийн асуулт бүхий асуулгыг ӨМӨЗО-ы үзэмчин угсаатнаас авч үзэмчин уртын дууны одоогийн ба ирээдүйн нөхцөл байдлыг гүймэг тодруулав. Асуулгаар,

- Үзэмчин уртын дуу (дуучид) -ны өнөөгийн нөхцөл байдлын талаарх сэтгэгдэл (эерэг)– 24%, боломжтой 26%, тааруу 50%
- Үзэмчин уртын дууны цаашдын байдлын талаарх сэтгэгдэл (өөдрөг) - 36%, улам муудна гэсэн хандлагатай 21%, хэлж мэдэхгүй 43% гэсэн дүн гарав.

Монгол Улс дахь үзэмчингүүдийн уртын дууны бүрэлдэхүүн буюу залгамж чанар үндсэндээ аюулын ирмэгт ирсэн нь 2022-2023 оны хугацаанд Дорнод, Сүхбаатар аймаг болон Улаанбаатарт оршин сууж байгаа үзэмчингүүдэд хийсэн судалгаагаар тогтоогдож байгааг хойшид дэлгэрүүлэн үзэх болно.

1.1. Судалгааны зорилго:

Үзэмчин уртын дууны жишээгээр нэг угсаатны ардын дууг аман зохиол судлалын үүднээс судлах боломжийг тодорхойлох,

1.2. Судалгааны хэрэглэгдэхүүн:

- Монгол Улсын болон ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Зүүн ба Баруун үзэмчний үзэмчингүүдийн дуулж ирсэн уртын дууны сан, архив, ном бүтээл дэх эх хэрэглэгдэхүүн, эмхэтгэл түүвэр, холбогдох дуу болон дүрс бичлэгийн болон цахим сүлжээн дэх эх хэрэглэгдэхүүн,

-Үзэмчингүүдийн оршин суугаа нутаг дэвсгэрт очиж ажилласан өөрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн.

1.3. Судалгааны арга, арга зүй:

Онолын чиг баримжаа

Бид энэхүү судалгаандаа нэгд, аман зохиолын онол (Folklore theory), аман зохиолын практик онол (Practice theory in Folklore)-оос үүдэн аялгуут аман зохиол, улмаар хөгжимт аман бүтээл (Folk music, Musican folklore) -ийн судалгааны гол үзэл чиглэлүүдийг түлхүү ашиглав.

Арга зүйн баримжаа

Дуу хураагуур, компьютер, дүрс бичлэгийн аппарат зэргийг ашиглан тэмдэглэж авах ажиглалтын арга; юмс үзэгдлийн дотоод мөн чанарыг тайлж

мэдэхийн тулд уг судлагдахууны оршин байх нөхцөл байдлыг зориудаар бий болгож, судлагдахууны төлөөлөгч цуглуулан, тандан судлах ярилцлага, боловсруулалтын аргууд, аман асуулга; ярилцлага; статистик, зураглалын гэх мэт аман зохиолын судалгааны аргуудыг хэрэглэсэн болно.

1.4. Судлагдсан байдал:

Үзэмчин угсаатны уртын дууг судалсан ном бүтээл тун ховор. Үзэмчний дууны урлагийн талаар ганц сэдэвт судалгааны бүтээл одоогоор байхгүй юм. Харин хэд хэдэн магистрын бүтээлүүд байна. Үзэмчин уртын дууны эмхэтгэл бол Ш.Чимэдцэеэгийн “Дарьганга, үзэмчин ардын урт, богино дууны түүвэр” (1995. Редактор Ж.Саруулбуян, Г.Мэнд-Ооёо), Өвөрмонголын судлаач Т.Санжаагийн “Үзэмчин ардын дуу” (1987, 2012), Н.Бөххад, Л.Отгонбаатар нарын “Үзэмчин ардын домогт дуу” (2005) зэрэг гол бүтээл юм.

Т.Санжаагийн эмхэтгэл анхдагч бөгөөд түүнд үзэмчний 76 уртын дууг багтсан бөгөөд аялгууг тоон ноотоор тэмдэглэжээ. Н.Бөххад, Л.Отгонбаатар нарын “Үзэмчин ардын домогт дуу” (2005) эмхэтгэлд төрийн 20 дуу, бурхан шашны 10 дуу, домогт 36 дуу, нийт 66 уртын дуу, мөн үзэмчин найрын 9 ая хөгжмийг хамран, тэдгээр дууны утга агуулга, домог, хууч яриаг хамруулжээ. Тус эмхэтгэлд үзэмчний дуу хэмээсэн ганц нэг дахин нягтлуултай дуу байхаас гадна зарим дууны үгийг буруу тэмдэглэсэн дутагдал ажиглагддаг.

Өвөрмонголын үзэмчин дууны бие даасан хоёр эмхэтгэлийг харьцуулахад 41 уртын дуу аль алинд нь байгаа бол, 25 дуу нь Т.Санжаагийн эмхэтгэсэн “Үзэмчин ардын дуу” (1987) номд байхгүй буюу шинээр нэмсэн дуу болно.

ӨМӨЗО-ы үзэмчин уртын дуучин Билэгтийн Мажиг 2002 онд Зүүн үзэмчин хошууны 50 жилийн ойд зориулан үзэмчний төрийн таван дууг дуулж, үзэмчний гарамгай уртын дуучин Мээдэг гуай 2012 онд Баруун Үзэмчин хошууны 2048 бөхтэй их найрт зориулан үзэмчний 14 уртын дууг дуулж, тус тус DVD гаргасан байдаг.

А.Тогтох 2014 онд “Үзэмчин найрын магнай дуунууд” хэмээх бүтээлээрээ Монгол Улсад магистрын зэрэг хамгаалахдаа 1646 онд Үзэмчин зүүн гарын хошуу, Үзэмчин баруун гарын хошуу хуваах үеэс эхлэн үзэмчин найрын магнайд дуулсаар ирсэн “Эртийн цагаан буян”, “Эрдэнийн галбирваас”, “Богд Чингис”, “Өнгийн гэрэл”, “Ариун тэнгэр” хэмээх таван дууг ноотлон тэмдэглэж, хөг аялгуу, яруу найраг, дуулах ур ухаан, дэс ёсны нь талаас судалсан юм.

Хамгийн сүүлийн бүтээл бол Да.Сэрэннамжил, Г.Цагаанхүү нар “Үзэмчин уртын дуу, түүний үүсэл гарал” судалгааны чанартай номыг 2023 онд хэвлүүлжээ. Бид, 2024 оны 7 сард зохиогчдын нэг, уртын дуучин Г.Цагаанхүүтэй уулзаж тодруулга авсан бөгөөд тус ном нь үзэмчний гол гол уртын дуу, тэдгээрийг дуулдаг шилдэг дуучидтай уулзсан маягаар дуу тус бүрийн онцлог, түүхийг өгүүлэх байдлаар зохиомжилжээ.

Судалгааны бүтээлүүдээс гарахад үзэмчний хэл аялгуу, аман зохиол, угсаатны соёлын судалгаа голлох байртай байгаа харин үзэмчин уртын дууны

судалгаа Монгол Улс, ӨМӨЗО алинд нь ч хоцрогдонгуй, эмхэтгэл түүвэр давамгай, судалгаа бага байна.

2. Үндсэн хэсэг

Үзэмчин уртын дууны хувилбаруудыг тооцоолж үзэхэд 1 дуу дунджаар 3-5 хувилбартай байна. Үзэмчин уртын дууны 86.2% нь хувилбартай, 13.8% нь хувилбар үүсгээгүй, зарим дуу урт болон богино аятай байгаагаас үзвэл үзэмчин уртын дуу хувилбарт “шүтэж” оршин тогтнож байна гэж үзэж болох юм.

Үзэмчин уртын дуунаас хамгийн олон хувилбар үүсгэсэн нь “Шижир богдын шил”, “Ар хөвч”, “Хүүхэн хутагтын дуу” зэрэг бол, “Ариун тэнгэр”, “Дөрвөн улирал”, “Баруун эх орон”, “Асар тансаг”, “Тэмүүжин Чингис”, “Овоот хамбын дуу” зэрэг дуу хамгийн бага хувилбарыг үүсгэжээ.

Үзэмчин уртын дуун хэвлэгдсэн баримтыг өөрийн олсон дууны тоотой нэгтгэн тооцож үзэхэд,

Төрөл анги		Монгол Улсын үзэмчин уртын дууны тоо
Архив, сан хөмрөг		25 (ШУА. Хэл зохиолын хүрээлэн)
Ном эмхэтгэл		
Өөрийн сурвалжилсан хувилбар	МУ-ын Дорнод аймаг	3
	МУ-ын Сүхбаатар аймаг	2
	ӨМӨЗО-ы Зүүн үзэмчин хошуу	5
	ӨМӨЗО-ы Баруун үзэмчин хошуу	5

Хүснэгт 2. Үзэмчин уртын дууны нэгдсэн дүн

Монгол Улс болон ӨМӨЗО-ы үзэмчингүүдийн дуулдаг дууны хувилбарууд ихээхэн сонирхол татсан агаад нэр, утга, сэдэв тэргүүтэн ижил боловч хэлбэр буюу урт богинын ялгаа их гарчээ.

Дууны хувилбаруудыг ажиглахад ном, эмхэтгэлд багтсан дууны үг шүлэг дэлгэрэнгүй, харин аман хувилбар хураангуй товч байна. Энэ нь дуучид уртын дууг бүрэн гүйцэд дуулдаггүй болсонтой шууд холбоотой бөгөөд ӨМӨЗО-ы Зүүн үзэмчин хошууны Гахил сумын уртын дуучин С.Отгонхүү (Эрэгтэй. нас 55. 2024 оны 6 сард уулзав) “Дууг дутуу, бүрэн гүйцэт биш дуулж байна. 6 бадаг дууг 2 бадаг л дуулдаг. Заримдаа аялах төдий л байна” гэсэн юм. Энэчлэн Монгол Улс, ӨМӨЗО-д бүртгэгдсэн үзэмчин уртын дууны шүлгийн бичвэрийн хэмжээг харьцуулахад ихээхэн өөрчлөлт ажиглагдав.

Үзэмчин уртын дууны хувилбарууд дахь өөр нэг зүйл бол цаг хугацааны хэмжүүрээр, өөр угсаатанд буй ижил дууны хувилбаруудын хооронд ихээхэн ялгаатай байдал байна. Үүнийг, үзэмчин, халхын “Өлийн даваа”, “Их богд”,

“Нарсан мод” зэрэг дуугаар жишээлж болно. Иймд аман зохиолын хувилбарууд дээр ажиллах арга үзэмчин уртын дууны хувилбарыг судлахад нэн тохиромжтой байлаа.


Бид үзэмчин уртын дууны загварчлалыг Аман зохиолын онолд тодорхойлсончлон дараах үе шатаар хураангуй байдлаар гаргав. Үүнд,

1. Судалгааны объектод хийсэн дүн шинжилгээ. Шилийн гол аймгийн хэмжээнд дуулагддаг урт, богино 420 дууг цуглуулж, түүнээсээ 205 уртын дууг ялган³ үзсэн нь Шилийн гол аймагт дуулагддаг уртын дуу болно. Эдгээр 205 уртын дуу буюу Шилийн голын уртын дуу нь ӨМӨЗО-ы хэмжээнд бүртгэгдсэн 2000 уртын дууны 9%-ийг дангаараа бүрдүүлж байгаа харьцангуй өндөр үзүүлэлт юм. Үүнийг цааш нарийвчлан Шилийн гол аймгийн хэмжээний 205 уртын дуунаас үзэмчинд дуулагддаг давхардаагүй тоогоор 101 уртын дууг тодруулан тархалт, бүрэлдэхүүн, сангийн бүрдэл, хувилбаруудыг бүртгэн тооцоолж үзэв.

2. Аялгуут-аман зохиолын загварчлал гаргах. Доктор А.Алимаа Монгол Улсын уртын дууны тархалтыг А,Б хоёр үндсэн бүсэд хуваагаад А бүсэд үзэмчин уртын дууг багтаан үзжээ (Алимаа, 2012, 124-125). Тэрээр энэ хуваарилалтаа газар нутгийн байрлал, угсаатны онцлог, аялгуу, хэв шинж, дууны яруу найргийн онцлог төлөв байдал гэсэн хэд хэдэн шалгуур тавьж А бүсийг дотор нь дэд бүсэд хуваахдаа “Зүүн дэд бүсэд үзэмчин, дариганга, барга, буриад” (Алимаа, 2012:131) гэж нэг бүлэгт хамруулсан байдаг. Түүнчлэн ӨМӨЗО-ы хувьд ч үзэмчингүүд газар зүйн байрлал, уртын дууны гол бүс Шилийн гол буюу зүүн бүсэд хамаарагдах боловч уртын дууны хувьд төвийн хэсгийг бүрдүүлдэг. Судалгааны энэ мэт чиг баримжаагаар үзэмчин дууны загварчлалыг аман зохиолын судалгааны бүртгэн баримтжуулах, газарзүйн тархалт зураглал хийх аргаар тооцоолон үзсэн болно.

³ Шилийн гол аймгийн Соёл, биеийн тамирын товчооноос эрхлэн хэвлүүлсэн “Шилийн голын ардын дууны эмхэтгэл” (2013. Голлон найруулсан Буян), “Өвөрмонголын монгол үндэстний уртын дууны хэв намбын орон, жич сонгодог ая дуу” (2018. 2 боть. Голлон найруулсан Жа Үй Гуан) зэрэг бүтээлийг хамруулсан.

Бүдүүвч 1. Үзэмчин уртын дууны бүс болон төрөл зүйлд хамаарах зураглал



Эх сурвалж: Аман зохиолын зураглал үйлдэх аргаар өрсдийн боловсруулсан бүдүүвч

3. Загварчлал болгосон үр дүнг үнэлэх. Бид шалгуур үзүүлэлтийг цааш нарийвчлан задалж үзэмчин уртын дууны онцлогийг тодруулах зорилтоо хэрэгжүүлэхийг хичээсэн бөгөөд үр дүнд нь үзэмчин уртын дууны харьяаллын бүсийг тогтоож монгол уртын дууны зүүн бүс дотроо уртын дууны гол бүрэлдүүлэгч болж байгааг энэхүү загварчлал харууллаа.

Д/д	Монгол уртын дууны Зүүн төвийн бүсэд хамаарах засаг захиргааны нэгж болон угсаатны бүлгүүд		Уртын дууны нийт тоо хэмжээ	Үзэмчин дууны тоо	Хувь хэмжээ
1	МУ-ын зүүн бүс	Дорнод	31	13	41.9%
		Сүхбаатар	43	8	18.6%
		Хэнтий	47	0	=
2	БНХАУ-ын ӨМӨЗО (Шилийн гол)	Сөнөд	24	8	33.3%
		Цахар	1	0	=
		Авга, Авга нар	12	3	25%
	Нийт		6 (7)	158	20.25%

Хүснэгт 3. Уртын дууны зүүн төв бүс дэх үзэмчин уртын баримжаа тоо

Монгол Улсын Зүүн бүсэд бүртгэгдсэн үзэмчин дуу гэвэл “Ганган хар”, “Алтан жигүүртэй чихжүхэй”, “Дөрвөн настай бор”, “Жаахан саарал”, “Жороо баахан”, “Жороо бор”, “Их богд”, “Өлийн даваа”, “Нарийн хөх”, “Нарсан мод”, “Сэрүүн сайхан хангай”, “Соёг бор”, “Саруул тал”, “Үүр сүүлт”, “Хөөрхөн халиун”, “Хээр халтар”, “Цагаан тохой нутаг”, “Эрдэнэ уул”, “Эрх зээрд”, “Эрдэнийн галбарбаасан” зэрэг дуу байна.

Ардын дууг аман зохиолын төрөл зүйлээр ангилах зарчмыг харгалзан ангилж үзсэн бөгөөд чингэхдээ:

- а) ахуй, аж амьдралын тодорхой зорилго,
- б) дууг дуулж буй нөхцөл,
- в) дууг дуулж дууссаны дараах нөхцөл” (Назайкинский, 2003: 94) гэсэн дууны хэрэглээний чанарыг байдлыг голлон анхаарах саналыг дэмжиж үзэмчний нийт дууг зан үйлийн зориулалт болон өөрийн хээрийн шинжилгээний явцад ажигласан байдлаар авч үзэхэд дараах дүн гарав.

анги	Шалгуур	Нийт дуунд эзлэх хувь хэмжээ
А	Үзэмчин уртын дууны зан үйлийн болон бусад чиг үүргийн зориулалттай дуунууд (нийгэм, төрийн, өдөр тутмын, хурим найр, цаг улирлын баяр, анагаах, ерөөх, сургамжлах, уран сайхны болон уран сайхны бус чиг үүрэг)	70%
Б	Дуулах үеийн зоригдол нь тодорхой дуунууд (соёл-ахуй, зан үйлийн нөхцөл, орон зай хандал, дуулах арга барил, хүмүүсийн харилцаа хандлага, хөгжмийн хамсраа гэх мэт)	14%
В	Дууг дуулж дууссаны дараах зан үйлийн нөхцөл нь тодорхой илэрсэн дуунууд (үр дүн, зан үйлийн хэсэг болсон эсэх)	16%

Хүснэгт 4. Үзэмчин уртын дууг төрөл зүйлээр ангилах шалгуураар тооцоолсон дүн

Эндээс үзэмчин уртын дуу нь ямар нэг зориулалттай буюу хэрэглээний үүрэг давуу байна. Уртын дууг дуулж байх үеийн зоригдол нь харилцааны (коммуникатив) чиг үүрэгтэй буюу хүмүүс хоорондоо, хүн байгаль, бурхан тахил, ээж гэх мэтчилэн ямар нэг зүйлд хандсан агуулгатай бол дууг дуулж дууссаны дараа тухайн зан үйл, зориулалт нь илүү тодорхой болж байх ажээ. Тухайлбал, хурим найрыг төгсгөх зориулалттай, найрыг хатуу дэг суларч, найр “хавтгайрах” үед чөлөөтэй дуулж болдог дуунууд ч байна.

Үзэмчин уртын дууны шүлэг яруу найраг, ая аялгуу, уран сайхан, мөн зан үйлийн функциональ байдал гэсэн шалгуураар үзэмчин уртын дууны төрөл зүйлийг ангилж болох юм. Үүгээр үзэмчний зан үйлийн уртын дууг: Төрийн ёслол буюу зан үйл, Иргэний зан үйл, Шашны зан үйл, тусгай зориулалтын зан үйлийн дуу гэж ялгах боломжтой. Эдгээрийг дотор нь нарийвчлан зүйлчилнэ.

Тухайлбал, иргэний зан үйлийн уртын дуу нь хурим, найрын, цаг улирлын баярын (уул овоо тахих, наадам г.м), хүүхэдтэй холбоотой зан үйлийн баярын, нийтийн зориулалттай зан үйл (алс хол мордох, аянаас ирэх, хүндтэй зочин ирэх, эмгэнэлийн г.м)

Энэ нь бусад монгол угсаатны уртын дууны төрөл зүйлийн ангиллаас хол зөрөхгүй бөгөөд үзэмчин судлаач У.Ёндон “Үзэмчин угсаатны түүх, соёлын товч тойм” номдоо уртын дууг “Их уртын дуу, энгийн урт дуу, найрын уртын дуу, ургийн урт дуу, шашин төрийн урт дуу гэж ялгадаг” (Ёндон, 2019, 179-180) гэсэн байдагтай үндсэндээ дүйж байгаа юм.

Энэ бүхнээс үзвэл монголын нэг угсаатан буюу үзэмчиний уртын дууг аман зохиолын онол, аргагүйгээр судлахад нэн тохиромжтой гэдгийг дахин өгүүлэх байна.

Дүгнэлт

Үзэмчин уртын дууны санг бүртгэн баримтжуулах явцад зөвхөн үзэмчинд байдаг, үүсэл гарлын түүх, домогтой, мөн бусад монгол угсаатны бүлэгт дуулагддаг ч үзэмчин аялгуутай зэрэг баримжаагаар үзэмчингүүдийн өөрийн дуу хэмээн итгэл үнэмшлээ болгосон 101 дууг тодорхойлсны дотор олон, цөөн хувилбартай дуу, төрөл зүйлийг тодорхойлов. Энэ бүх судалгаанд аман зохиолын онол, арга зүй нэг угсаатны уламжлалт дууг судлахад нэн тохиромжтой байна.

Судалгаандаа аман зохиолын хээрийн шинжилгээний аргагүйгээр Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-нд оршин амьдарч байгаа үзэмчингүүдийн нутагт хүрч 2020, 2023-2024 онд 2 үе шаттай хээрийн шинжилгээ хийж, тухайн нутгийн үзэмчин уртын дууг мэддэг, холбогдол бүхий нийт 50 орчим хүнтэй биечлэн уулзаж ажиглалт ярилцлага хийх явцад үзэмчин уртын дууны сан багасан хомсдох, дуу мартагдах (ялангуяа аялгуу), аялгуу бэсрэгжих үйл явц хурдтай байгаа нь анхаарал татаж байна.

Үзэмчин уртын дууны санг авч үзэхэд зан үйлийн дуу давамгайл байгаа нь үзэмчингүүдийн дунд зан үйлийн буюу хэрэглээний уламжлал өндөр байж, ямарваа зан үйлийн өмнөтгөл буюу зориулалт нь тодорхой дуу зан үйлийн дууны 70 хүртэл хувийг эзэлж байгаа судалгааны баримт харуулна. Гэвч өнөөдөр үзэмчин уртын дуу багасаж байгаагийн шалтгаан найр наадамд нийтийн болон шинэ дуу дуулах, мэргэжлийн дуучид урин ирүүлж найр наадмаа хөгжөөх байдал ихэссэн нь аажимдаа зан үйлийн шинжтэй дуунууд, дууны зориулалтын ялгаа арилах хандлагатай байна. Үзэмчин уртын дуу, ялангуяа Монгол Улсын үзэмчин уртын дууг яаралтай хамгаалах арга хэмжээг авах, үзэмчин зан үйлийн орчныг дэмжих, сургалт зохион байгуулах шаардлагатай гэж үзлээ.

Ном зүй

А. Монгол хэлээр:

Алимаа, А. (2012). *Уртын дууны төрөл зүйл, тархалт, хувилбарын онцлог*, Улаанбаатар: Х пресс. [Alimaa, A. *Urtiin duunii töröl züil, tarkhalt, khuvilbariin ontslog*. Ulaanbaatar: Kh press. 2012]

Ёндон, У. (2019). *Үзэмчин угсаатны түүх, соёлын товч*, Зүүн үзэмчин хошууны Соёл түүхийн нийгэмлэг. [Yondon, U. *Üzemchin ugsaatsanii tiiikh, soyoliin товч*. Ulaanbaatar: 2019]

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого-Хүн амын өсөлт, нас, хүйсийн бүтэц (2020). Товхимол-тайлан, Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо,

Б. Гадаад хэлээр:

Назайкинский, Е.В. (2003). *Стиль и жанр в музыке: учеб. пособие для вузов*. ВЛАДОС.

Чичеров, В.И. (1959). *Русское народное творчество*. Москва., Изд-во Москва ун-та,

Alan Lomax. (1956). *Folk Song Style: Notes on a Systematic Approach to the Study of Folk Song*, Journal of the International Folk Music Council. Vol. 8 (1956), pp. 48-50 (3 pages). Cambridge University Press.

Thomas A, Burns. (1977). *Folklorists: A conception of Theory*. Journal of American Folklore. The article was published on 01 Apr 1975, pp. 109-136. Western Folklore.

В. Цахим эх сурвалж:

https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=1.Summary%20report_Ulaanbaatar.pdf&ln=Mn 2021-12-30. 3,876. Файлын хэмжээ: 2.41 MB. pdf.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.